

ОРХОН АЙМГИЙН НОГООН, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ (2026)-ЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ -2023 ОН

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

2023.12.04

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хэрэгж илтийн хувь
1	Зорилт 1.1. Бүх хүн ам, ялангуяа нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэнд хүртээмжтэй, баталгаатай үндсэн суурь үйлчилгээ болон нийгмийн хамгааллын үйлчилгээг бүрэн үзүүлж, хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэх	1.1.2 ХБИ, ахмад настанд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж хамгааллын үйлчилгээг сайжруулах	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор нийт 2623 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 18361 урт болон богино хугацааны сэргээн засахын тусламж үйлчилгээг үзүүлсэн. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт 3645 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамруулахаас 2129/58,4%/ иргэн хамрагдсан бөгөөд хүүхдийн үзлэгт 418 /76,6%/ хүүхэд, насанд хүрэгчдийн үзлэгт 1,808 /56%/ байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагаар 15044 ахмад үйлчлүүлснээс 56,4% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, сэтгэц зан төрийн эмгэгтэй 7, насны доройтолтой 28, хөгжлийн бэрхшээлтэй 806 ахмад анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагад хянагдаж байна. Эрүүл-"Эрүүл эрдэнэт хүн" төсөл, нээлттэй хаалганы өдрүүдээр 2660 ахмадыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 518 ахмадад эмчилгээнд хамруулж, 74 ахмадыг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээсэн байна. Зорилтот бүлгийн IV, V бүлгийн 924 ахмад сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, 27 ахмад Бүсийн оношилгоо эмчилгээний төвд тусламж үйлчилгээнд хамрагдсан. Нийгмийн хариуцлагын хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүд 250 ахмадад тус бүр 60,000 төгрөгийн аминдэмийн багц хүргэсэн байна.	90
2	Зорилт 2.1. Хүн ам, ялангуяа ядуу болон бага насны хүүхэд, өсвөр насны охид, жирэмсэн болон хөхүүл эхчүүд, өндөр настныг тэжээллэг эрүүл ахуйн баталгаатай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах.	2.1.1 Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт аминдэмд хамруулах ажлыг зохион байгуулах	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/195 дугаар захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20100 ширхэг аминдэмийг хуваарилан 689 эхийг 100% аминдэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 689 эхээс цус багадалттай 264 эх байгаа нь 38.3 хувийг, нийгмийн халамж дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн 128 эх, эх барихын ужиг дутагдалтай 297 эхийг аминдэмжүүлж, эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Эхийн аминдэмийн төсөв өмнөх онтой харьцуулахад 42 хувиар, аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.4 дахин нэмэгдсэн.	100
3		2.1.3 Монгол хүний зохистой хооллолтын зөвлөмжийн дагуу, хүн амын хоол тэжээлийн	Монгол хүний зохистой хооллолтын зөвлөмжийн дагуу, хүн амын хоол тэжээлийн талаарх боловсролын дээшлүүлэх зорилгоор 1550 хүнийг сургалт, сурталчилгаанд хамруулсан Үүнд: - Хүнсний бүтээгдэхүүний шошгод харшил үүсгэдэг орц бүтээгдэхүүнийг	70

	талаарх боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	<p>зөв таних, шошгын хэрэглээ, эрүүл зөв хооллох мэдлэг, хандлага, дадлын төлөвшүүлэх зорилгоор 2 удаагийн сургалтад сургууль цэцэрлэгийн 208 эмч, хоол зүйч, эрүүл мэндийн хичээл заадаг багш нар</p> <ul style="list-style-type: none"> - Баяжуулсан хүнсний хэрэглээгээр 360 хүн - 5 удаагийн сургалтад хоол хүнс үйлдвэрлэгч давхардсан тоогоор 528 хүн - Зорилтот бүлэгт чиглэсэн 3 удаагийн сургалтад 51 хүнийг тус тус хамруулсан. - Мөн 4 удаагийн өдөрлөгт 403 хүнийг хамруулан эрүүл мэндийн 7 үзүүлэлтийг аппаратаар биеийн жингийн индекс тодорхойлон зөвлөгөө өгсөн. - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3 удаагийн мэдээллийг иргэдэд хүргэсэн. <p>Эрүүл зөв хооллолт, давсны зохистой хэрэглээний талаарх зөвлөмж видео шторкуудыг цахим хуудсаар байршуулан давхардсан тоогоор 361890 хүнд хүргэсэн.</p>	
4	2.1.5 Баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх талаар иргэдэд хандсан сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ	<p>Баяжуулсан хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтад сургууль, цэцэрлэгийн хоол зүйч, эмч 115 хүнийг хамруулсан.</p> <p>Баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд 6 сараас дээш настай хүүхдийн нэмэгдэл хоолыг бэлтгэх аргачлал, хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах дадлага бүхий сургалт, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ зэрэг сургалтуудад 191 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан 17 төрлийн нэмэгдэл хоол бэлтгэх аргачлалд сургасан.</p> <p>Баяжуулсан нэмэгдэл хоол тэжээл бэлтгэх аргазүйн зөвлөмж, гарын авлагыг 152 эцэг эх асран хамгаалагчид түгээсэн. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс бэлтгэсэн 2 төрлийн баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний талаарх видео контентыг цахимаар сурталчлан 10963 хүнд хүргэсэн байна.</p>	90
5	2.1.6 Эрүүл мэндийн газрын зохистой хооллолтын кабинетыг тогтмол ажиллуулж жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхэд, асран хамгаалагч, иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулна	<p>“Хоол шим тэжээлийн боловсрол олгох танхим”-д үзүүлэн, самбар, хүнсний нэгжийг сурталчлах шүүгээ бүхий иж бүрдэл сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангагдаж сургалтын дэмжлэгт орчныг бүрдүүлэн, үйл ажиллагаа тогтмолжсон. Тайлан хугацаанд тус танхимаар:</p> <ul style="list-style-type: none"> - Зорилтот бүлэгт чиглэсэн 3 удаагийн сургалт зохион байгуулж 51 хүнийг хамруулсан. - 691 иргэний биеийн бүтэц, эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тодорхойлоход 61.3% нь эрүүл бус хооллодог, биеийн жингийн индексийн дундаж эрэгтэйд 27.9 кг/м.кв, эмэгтэйд 28.7 кг/м.кв буюу хэвийн үзүүлэлтээс өндөр, 30.8% нь илүүдэл жинтэй, 44,9% нь таргалалттай байна. Хүн бүрт үзүүлэлтийн дагуу зөвлөмж өгч ажилласан. - Хөхөөр хооллолт, эхийн сүүгээр дагнан хооллох чиглэлээр ач тус, нялх 	90

			балчир хүүхдийн хооллолтын тухай хуулийг сурталчлах чиглэлээр зөвлөгөө мэдээллийг нийт 1875 иргэнд хүргэсэн байна.	
6		2.1.7 Нийтийн хоол үйлдвэрлэлийн хоолны шим тэжээл, чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах, нийтийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох	<p>Тайлант хугацаанд хоол хүнс үйлдвэрлэгч нарт 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 528 хүнийг хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Тогоочдын холбоо, Монголын ахлах тогоочийн академитай хамтран аймгийн хэмжээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, салбарын мэргэжилтэй ажиллагсдыг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үйлдвэрийн газар, зоогийн газрын нийт 230 тогооч, эмч, хоол зүйч нарыг хамруулан сертификат олгосон. - Баяжуулсан хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр 2 удаагийн сургалтад сургууль, цэцэрлэгийн хоол зүйч, эмч 115 хүнийг хамруулсан. - Үдийн хоолны чанарыг сайжруулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын хоол зүйч нарыг чадавхжуулах 3 удаагийн сургалт зохион байгуулж 36 хүнийг хамруулсан. - Нийтийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй нийт 183 иргэнд Онцгой байдал, Эрүүл мэндийн газар, Монголын тогоочдын холбоотой хамтран хүнсний аюулгүй байдлыг хангах талаар 2 удаагийн сургалт зохион байгуулж, 122 ширхэг зөвлөмжийг иргэдэд хүргэсэн байна. - “Хүнсний аюулгүй байдлын цаг” тусгай хөтөлбөрт хамтран оролцож 3 удаагийн мэдээллийг хүргэсэн байна. <p>Хүнсний боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 үйлдвэр, цехэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний давсны орц, найрлагыг бууруулах зөвлөмж мэдээлэл хүргэж ажилласан. Түүврийн аргаар орон нутагт үйлдвэрлэгддэг 8 хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн 9 дээж авч, давсны агууламжийг тодорхойлоход бүгд зохист хэмжээнд хэрэглэж хэвшсэнээс гадна бүтээгдэхүүний давсны агууламжийг өмнөх оноос 53.0 хувиар бууруулсан байна</p>	90
7		2.1.9 Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх	<p>Тайлант хугацаанд:</p> <p>Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтад 1550 хүнийг хамруулсан байна</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд “Хүнсний аюулгүй байдлын цаг” тусгай хөтөлбөрт сард нэг удаа мэдээлэл хүргэн ажиллаж тус хугацаанд 3 удаагийн мэдээллийг хүргэсэн байна.</p> <p>БШУГ-тай хамтран эрүүл мэндийн хичээл заадаг 110 багшид шим тэжээл, өглөөний хоолны ач тус агуулгын хүрээнд сургалт зохион байгуулсан.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран сургууль, цэцэрлэгийн</p>	90

			бага эмч, болон эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор эрүүл зөв хооллолтын чиглэлээр 5 сэдвийн хүрээнд цахим сургалт зохион байгуулж нийт 80 хүнийг хамруулсан. Цахим хуудсаар хүнсний аюулгүй байдал сэдвийн хүрээнд зурагт мэдээллийг 50968 хүний түгээсэн.	
8	Зорилт 3.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд зөв амьдралын дадлыг хэвшүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах.	3.1.1 Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж бүх шатны төрийн болон аж ахуй нэгж байгууллагын оролцоог сайжруулан, үүрэг хариуцлага, үр дүнг тооцон ажиллах	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 673698 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 229454 хийгдэж, нийт үзлэгийн 34,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0,3 хувиар буурсан. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг 89.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 57.0 хувиар нэмэгдсэн байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд 53 төрийн болон аж ахуй нэгж байгууллагын 1498 албан хаагчдыг эрт илрүүлэгт хамруулан хамтран ажиллаж эрт илрүүлэг үзлэг 9,6 хувиар нэмэгдсэн. Аймгийн Засаг даргын А/656 тоот захирамжаар “Эрүүл Эрдэнэт хүн” тусламж үйлчилгээний төслийг хэрэгжүүлэхээр 90.0 сая төгрөгийг шийдвэрлэн хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмаар өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн 31074 иргэнд 13 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлснээс эрүүл мэндийн даатгалгүй 955 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт 43660 иргэн буюу нийт хүн амын 41,1 хувь нь үзлэгт хамрагдсанаас 0-17 насны хүүхдийн 74,5% үзлэгт бүрэн хамрагдаж улсын хэмжээнд хүүхдийн үзлэгээр тэргүүлж байна. 18-аас дээш насанд 16197 хүн хамрагдаж хамруулахаар төлөвлөсөн хүн амын 23,5% үзлэгт бүрэн хамрагдсан. Үзлэгээр 26492 хүнд зөвлөгөө өгч, 3894 хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад, 6633 хүнийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлсэн байна. 30283 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн ба хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр амны хөндийн өвчлөл, насанд хүрэгчдийн үзлэгээр хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл тэргүүлж байна.	70
9		3.1.2 "Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих" бүх нийтийн аян өрнүүлэн, "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага"-ыг нэмэгдүүлэх	Тайлант хугацаанд шинээр 5 байгууллага Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болж, 4 байгууллага зэрэглэл ахиулсан байна. 21 төрийн байгууллагын 1180 албан хаагчийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулж, "Энэ жилдээ эрүүл жиндээ" аяны хүрээнд жин бууруулах 1 сарын уралдааныг 10 байгууллагын 60 хүнийг хамруулж зохион байгуулснаар аяны хугацаанд оролцогчид нийт 93.4 кг жин хаяжээ. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 81 байгаагаас боловсролын салбарын 45, эрүүл мэндийн салбарын 14, үйлдвэр аж ахуйн нэгж 12, бусад 10 байгууллага байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл мэндийг	100

			дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөгийг шийдүүлэн ажилласан.	
10	Зорилт 3.2. Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэлт, дэвшилтэт ээлтэй шинэ технологи бүхий эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах замаар нас баралтыг бууруулах	3.2.1 Зонхилон тохиолдох халдварт бус өвчин болон орон нутгийн тэргүүлэх өвчлөлд жил бүр судалгаа хийх	<p>Тайлант хугацаанд эрдэм шинжилгээний бага хурлаар 30 илтгэл хэлэлцүүлэгдсэн. Тайлант хугацаанд 3 судалгаа хийгдсэнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбарын 21 байгууллагын 405 эмч эмнэлгийн мэргэжилтний ажлаас халшрах хам шинжийг илрүүлэх судалгаагаар үйлчлүүлэгчдийг сэтгэлээрээ мэдрэх чадвар буурах шинжийн хувьд 36.9% өндөр, 22.5% дунд, хувь хүний бүтээмж буурах байдал 31.2% өндөр, 17.6% нь дунд, бие хүний сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийн шинжээрээ 13.4% нь өндөр түвшинд, 25% нь дунд үүнээс 4% нь ажлаас халшрах хам шинжтэй, 3.7% ажлаас халшрах хам шинжид өртөх магадлал өндөр байна. Судалгааны дүнд дүгнэлт хийж, сэтгэл зүйн сургалт, ярилцлага зохион байгуулан 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний 6-р судалгаанд 288 иргэний хоол тэжээлийн үнэлгээ нэгтгэгдэж байна. - Зөвийг дадал болгоё” төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн 200 хүүхэд, 600 эцэг эхийг хамруулсан амны хөндийн эрүүл ахуйн талаарх мэдлэг хандлага дадлыг үнэлэх судалгаагаар оо, сойзыг тогтмол хэрэглэдэг. Мөн туслах хэрэглэгдэхүүн шүдний утсыг 54,3% (n=100) нь хэрэглэдэг, асран хамгаалагчийн мэдлэг 87,2%, хандлага 75.9%, дадал 64.7%-тай байна. <p>2023 оны 11 сарын байдлаар халдварт бус өвчний тохиолдол 68402 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,8 хувиар буурсан байна. Үүнээс 34251 өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн ба 42,9 хувь нь эрэгтэй, 57,1 хувь нь эмэгтэй байна. 20-59 насанд нийт өвчлөлийн 53% бүртгэгдсэн байна. Халдварт бус өвчнөөс амьсгалын эрхтэн тогтолцоо, хоол боловсруулах замын эрхтэн тогтолцоо, зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл тэргүүлж байна.</p>	90
11		3.2.2 Халдварт бус өвчний илрүүлэлтийг үе шаттайгаар зохион байгуулах	<p>Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Тайлант хугацаанд халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг 89.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 57.0 хувиар нэмэгдсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-с дээш насны нийт 47765 буюу хамрагдвал зохих хүн амын 90.0 хувийг эзэлж, өмнөх оноос (47.8) хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 0.9 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 40-дээш насны нийт 27420 буюу хамрагдвал зохих хүн амын 109.7 хувийг эзэлж, өмнөх оноос (57.5) хувиар өсч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувь онош батлагдсан 	90

			<p>байна.</p> <ul style="list-style-type: none"> - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2931 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 105.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (79.2) хувиар өссөн. Пап шинжилгээнд нийт 1215 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 16527 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 87,4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (50,6) хувиар өссөн байна. - Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 887 хүн буюу (54.8) хувь нь хамрагдсан. <p>Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер, зөвлөмжийг 3200 иргэнд, цахимд 131 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 443651 иргэнд хүргэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 24 удаагийн ярилцлагыг иргэдэд хүргэсэн.</p>	
12		<p>3.2.3 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Орон нутгийн төсвөөс 20 сая төгрөгийг шийдвэрлүүлэн зорилтот бүлгийн 16-49 насны 2000 эмэгтэйг нөхөн үржихүйн болон бэлгийн замаар дамжих халдварын үзлэг шинжилгээнд 1895 буюу 94,7% хамруулж, лавлагаа шатлалд 457 эмэгтэйг илгээн, эмчлэн эрүүлжүүлсэн 354 буюу 77,5% нь бүрэн эмчлэгдсэн.</p> <p>Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хангалт 75.8 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар нэмэгдсэн.</p> <p>Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдийн 22 хувь нь үзлэгт хамрагдсан байна.</p>	100
13		<p>3.2.4 Засгийн газрын “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгүүдэд элэгний хорт хавдар, В,С вирусийн халдварыг эрт илрүүлж, өвчлөлийг бууруулах, эмчлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Тайлант хугацаанд элэгний В вирус илрүүлэх шинжилгээнд 3620 иргэн хамрагдсанаас 120 хүн буюу 3.3%, С вирус илрүүлэх шинжилгээнд 3610 иргэн хамрагдсанаас 121 буюу 3.4% нь эерэг илэрч 65 хүн эмчилгээнд хамрагдсан. Нярайн төрсний дараа 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 99.7 хувь, 2 настай хүүхдийн А вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 100 хувьтай байна. В вирусийн эсрэг тархвар судлалын заалтаар дархлаажуулалтад 1522 иргэн хамрагдсан. Элэгний В, С вирусээс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг таниулах 7 төрлийн зурагт хуудсыг цахимаар 8081 хүнд түгээж, 88 хүнийг сургалтад хамруулсан байна.</p> <p>Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын 231 эмч буюу нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 26.4 хувийг хамруулсан байна.</p> <p>Тайлант хугацаанд вируст гепатитын 6 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.6 промилл байна. Тайлант хугацаанд элэгний хорт хавдрын нас</p>	70

			баралт 45 тохиолдол 10000 хүн амд 4.2 промилл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 промилл буурсан, элэгний хатуурлын нас баралт 11 тохиолдол 10000 хүн амд 1.0 промилл өмнөх оны мөн үеэс 0.1 промилл буурсан. Тайлант хугацаанд “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хэрэгжилт 85.8 хувьтай байна.	
14	3.2.5 “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аяныг зохион байгуулах, үйл ажиллагааг нь дэмжиж ажиллах		“Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аян 2016-2020 онд хэрэгжиж дууссан. Тус аяны хүрээнд В, С вирусийн шалтгаант өвчлөлтэй 2,116 иргэнийг бүртгэлжүүлж, 5,857 иргэн элэгний өвчлөл болон амьдралын буруу дадлын талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамрагдсан. Гепатитын В, С вирус тодорхойлох шинжилгээнд 16100 иргэн хамрагдсанаас 1,133 хүн эмчлэгдэн эрүүлжсэн байна. В вирус тээгч эхээс төрсөн нярайг В вирусийн халдвараас сэргийлэх зорилгоор “Нераbig” иммуноглобулиныг 226 нярайд хийж халдвараас сэргийлсэн байна.	100
15	3.2.6 Сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношилгоо эмчилгээг сайжруулан, тандалт судалгааг зохион байгуулах, сүрьеэгийн халдварыг түргэн хугацаанд оношлох шинэ технологийг нэвтрүүлж, дижитал рентген аппаратаар хангах		Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 59 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 5,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,8 промиллоор нэмэгдсэн. Тус хугацаанд нийт хийгдсэн үзлэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн дундаж хувь 82,5% байна. Үүнд: - Сүрьеэгийн диспансераар 4267 үзлэг хийгдсэнээс 3345 буюу 78.4% нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна. - Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг сум, өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн ерөнхийн газартай хамтран 3 удаа зохион байгуулж 926 иргэнийг цээжний рентген, хавьтлын 64 иргэнд туберкулины сорил тавьж цээжний рентгенд өөрчлөлттэй 40 иргэнээс цэрний сорьцод шинжилгээ хийв. Үүнээс сүрьеэгийн 8 тохиолдол, 4 далд халдвар илэрч нийт 11 тохиолдлыг эмчилгээнд хамруулсан. - Молекул биологийн GeneXpert-ээр 252 тохиолдолд шинжилгээ хийснээс уушгины түрхэц сөрөг 6, эмэнд дасалтай 4 далд хэлбэрийн сүрьеэ өвчнийг илрүүлж, эмчилгээнд хамруулсан. Сүрьеэгийн диспансерын хяналтад 37 өвчтөн эмчлэгдэж байгаагаас эмэнд мэдрэг сүрьеэ 36 (97.3%), нэг ба олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээтэй 1 (2.7%) байна. Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрийн хүрээнд 4 удаагийн сургалтад 216 хүнийг хамруулсан. Монголын Сүрьеэтэй Тэмцэх нийгэмлэгийн 8 эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн 16 хүний эмийг гэрээр хяналттай уулгасан. Мөн тус нийгэмлэгээс эмчилгээнд хамрагдаж буй 35 өвчтөнийг аминдэмжүүлж, амьжиргааны баталгаажих түвшин доогуур орлоготой 8 өвчтөнд сар бүр хүнсний тусламж үзүүлсэн байна.	90
16	3.2.7 Хүн амын дундах ДОХ/ХДХВ/БЗДХ- ыг эрт		Тайлант хугацаанд: - Орон нутгийн төсвөөс 20 сая төгрөгийг шийдвэрлүүлэн зорилтот бүлгийн	90

	илрүүлэх, эмчлэх эрчимжүүлэх	оношлох, ажлыг	<p>16-49 насны 2000 эмэгтэйг нөхөн үржихүйн болон бэлгийн замаар дамжих халдварын үзлэг шинжилгээнд 1895 буюу 94,7% хамруулж, лавлагаа шатлалд 457 эмэгтэйг илгээн, эмчлэн эрүүлжүүлсэн 354 буюу 77,5% нь бүрэн эмчлэгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Бэлгийн замаар дамжих халдварын кабинетаар 4742 хүнд үйлчлүүлснээс 76.1% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. - Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ХДХВ-ийн шинжилгээнд 3460, тэмбүүгийн шинжилгээнд 3824 иргэнийг хамруулсан байна. - Шинээр хяналтад хамрагдсан 1451 жирэмсэн эмэгтэйн бэлгийн замаар дамжих халдварын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 25 буюу 1.9 хувь нь эерэг, тэмбүү 8 буюу 0.6 хувь нь эерэг, заг хүйтэн 1 буюу 0.07 хувь эерэг гарч 100% эмчилгээнд хамрагдсан. - ДОХ/ХДХВ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэхийн ач холбогдлыг таниулах 14 төрлийн зурагт хуудсыг цахим орчинд байршуулан 19385 хүнд хүргэсэн байна. - Эрүүл мэндийг дэмжих сангийн 13,5 сая төгрөгийн санхүүжилтээр “Ний нуугүй ярилцъя” төслийн хүрээнд 1000 хүн, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран “Би найзынхаа итгэлтэй зөвлөх” нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замын халдвараас сэргийлэх сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 168 хүүхэд, 86 оюутныг хамруулсан байна. <p>Тайлант хугацаанд бэлгийн замаар дамжих халдварын 134 тохиолдол бүртгэгдсэнээс 42.5%-ийг тэмбүү, 14.2%-ийг заг хүйтэн, 43,3%-ийг трихомониаз тус тус эзэлж, 10000 хүн амд 12,7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,8 промиллоор буурсан байна.</p>	
17	3.2.8	Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ болон их, дээд сургуулиудыг их эмчтэй болгох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	<p>Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан “Үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай” 2018 оны А/494, А/761 дүгээр тушаалаар ерөнхий боловсролын сургууль болон хүүхдийн цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлагдаж, хүний их эмч, сувилагч, бага эмчийн мэргэжлийн дипломтой хүн сургууль, цэцэрлэгийн эмч хийхээр тусгагдсан.</p> <p>Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн 26 ерөнхий боловсролын сургуульд 26 бага эмч, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 30 бага эмч, сувилагч ажиллаж байна. Эрдэнэт их сургуульд 1 их эмч, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд 2 бага эмч ажиллаж байна. Эрүүл мэндийн газраас дээрх сургуулиудын эмч нарыг сар тутам 2 удаа шинэ мэдээллээр ханган, чадавхжуулах сургалтад хамруулан, мэргэжил арга зүйгээр ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан.</p>	100
18	3.2.9	Хүүхдийн амны	2017-2019 онд ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх 3, 4, 5 дугаар	-

	хөндийн өвчнийг оношлох, эмчлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудад шүдний кабинет, лабораториудыг байгуулах ажлыг судлах	сургуулийн дэргэд орон нутгийн санхүүжилтээр шүдний кабинет ажиллуулсан. 2020 оноос хойш шүдний эмчийн цалин, шүдний эмчилгээний эм, материалыг худалдан авах зардал төсөвт суугдаагүй, хүний нөөцийн дутагдалтайгаас ажиллаагүй байна.	
19	3.2.10 Хуулийн дагуу оношилгооны урвалж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангах, гэрээгээр хангагдаж байгаа эмийн чанар хүртээмж хэрэглээнд хяналт тавих, худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд нээлттэй болгох.	Тайлант хугацаанд БОЭТ-д төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур худалдан авах тендерт нийт 61 багцад зарласан бөгөөд Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж 2 /62,63/ багцыг зориулалтын дагуу задлан нийт 63 багцад 100% амжилттай зохион байгуулж, 22 компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Мөн 2023 онд худалдан авах ажиллагааны нийт төсөвт өртөгт 6,3 тэрбум төгрөг үүнээс нээлттэй тендер шалгаруулах журмаар 5,5 тэрбум төгрөг /87,3%/, ерөнхий гэрээгээр 80 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийг 800 сая /12,7%/-д худалдан авахаар 16 компанитай гэрээ байгуулан худалдан авч ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт төсөвт өртөг 6,3 тэрбум төгрөг байгаа нь 42,06%-аар нэмэгдсэн. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2.45 тэрбум төгрөг буюу 44,5%-аар, ерөнхий гэрээгээр 200 сая төгрөг буюу 75%-аар илүү төсөвлөгдсөн байна. Мөн худалдан авах ажиллагааг зөвхөн гэрээ байгуулсан 38 компаниас авч ажилласан. шалгаран гэрээ байгуулан нийлүүлсэн. Тайлант хугацаанд ЭХНБ, эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 93,5%-тай байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 0,6%-аар өссөн үзүүлэлттэй байна. Давхардсан тоогоор 11 байгууллагад 4735 мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг дугаарлаж олгосноос мансууруулах эмийн жорыг 5 байгууллагад нийт 614/12,97%/ жорыг, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 9 байгууллагад 4,121/87,03%/ жорыг тус тус дугаарлан олгож хяналт тавин ажилласан. Худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд нээлттэй ил тод байдлыг хангахаар эмийн сангууд эмийн үнийг иргэдэд харагдахуйцаар байршуулан, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шинэчлэн батлагдсан тогтоолыг хэвлэмэл нэг төрлийн самбараар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.	100
20	3.2.11 Цахим эрүүл мэндийн төслийг хэрэгжүүлэх	Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд хийгдэж буй нэгдсэн платформд “Эрүүл мэнд” аппликейшнийг хөгжүүлж	100

			байна. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн дуудлагын үед цахим программд үзлэгийн бүртгэл хөтлөх ажиллагааг хялбаршуулах, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичиж, кодыг олгох зориулалтаар ашиглах зөөврийн 20 ширхэг планшетаар хангасан.	
21	3.2.16 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн цаг товлох, хөтөч, лавлагаат үйлчилгээг өргөжүүлэх	<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь цаг товлолд нарийн мэргэжлийн кабинетуудын эмчийн үзлэгийн цагийг өмнө нь 1-2 сарын хүлээгдэлтэй өгөх арга хэмжээг авч байсан боловч тухайн өдөр цаг авсан үйлчлүүлэгч ирэхгүй байх тохиолдол их, зохиомол хүлээгдэл үүсэж байсан тул эмчийн үзлэгийн цагийг 7 хоноогоор өгөх зохицуулалт хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Тайлант хугацаанд өмнө нь 1 эмчтэй хүлээгдэл ихтэй байсан Элэг цөс, Эмэгтэйчүүд, Хүүхдийн кабинетыг 2023 оны 10 дугаар сараас эхлэн 2 эмчтэй ажиллуулж эхэлснээр хүлээгдэл 3-5 хоноогоор буурч, хүлээгдэл 1 хоногтой байна. - Жирэмсний онцгой хяналтын кабинет 3 эмч ажилладаг, хүлээгдэл 5-7 хоног байсныг 4 эмчтэй болгосноор жирэмсэн эхчүүдийг цаг товлохгүй, хүлээгдэлгүй үзэж байна. - Зүрх судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн 3 эмч бүрэн орон тоогоор ажиллаж эхэлсэн. <p>Амбулаторийн эмчийн үзлэгийн цагийг өөрийн биеэр ирэх, 77000040 утсаар, ЭМХТ-ийн 1800-0119 утсаар, E-mongolia аппликейшин ашиглан иргэд захиалж байна. Тайлант хугацаанд e-mongolia app-аар 3266, 18000119 утсаар 153, 77000040 утсаар 38769, танхимаар 179406 нийт 221594 иргэнд цаг товлох үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторид 6 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 92% болж, өмнөх оны мөн үеэс 8%-иар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 85.5 хувиар багассан. Цаг товлолыг сараар биш долоо хоноогоор бүртгэдэг болсноор иргэд үзүүлэх цагаа долоо хоног бүр хурдан шуурхай авдаг болсон. Эмч нарын цагийг иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор хөндлөнгөөс хянадаг болсноор ажлын цаг ашиглалт, үйл ажиллагаа эрс сайжирч, иргэдийн хүлээгдэл 88.2 хувиар багассан.</p>	90	
22	3.2.7 Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэх	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2023 оны А/204, А/460, А/706 дүгээр захирамжаар 109 иргэнд 43,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацаанд хавдрын 159 тохиолдол бүртгэгдэж, хяналтад орсноос эмийн болон эмчилгээний дэмжлэгт 69,2 хувь нь хамрагдсан байна.	100	

23		<p>3.4.1 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг цогц байдлаар зохион байгуулах, шинээр байгуулагдсан хорооллын дунд эрэлт хэрэгцээ, стандартыг үндэслэн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шинээр ажиллуулан, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулах</p>	<p>Орхон аймагт 8 өрхийн эрүүл мэндийн төв 10 байранд үйл ажиллагаа явуулж байгаагаас 4 нь өрхийн эрүүл мэндийн төвийн зориулалтын байранд, 2 нь эмнэлгийн зориулалтын байранд, 4 нь төрийн үйлчилгээний эмнэлгийн бус байранд нийт өрхийн 48 эмч, 49 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн 43 ажиллаж иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Тайлант хугацаанд аймгийн нийт үзлэгийн 47.9 хувийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хийж лавлагаа шатлалын ачааллыг хуваалцаж ажилласан байна.</p> <p>Аймгийн Засаг даргад Мэндцэцэн, Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид үнэлгээ хийн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, хүн ам, үйлчлэх хүрээг шинэчлэн тогтоож шинэ өрхийн эрүүл мэндийн төв байгуулах болон Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилга байгуулах хүсэлтийг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажилласан.</p>	90
24	<p>Зорилт 3.4. Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, хариуцлагатай, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх.</p>	<p>3.4.2 Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмж, нөхөн сэргээх эмчилгээ, лабораторийн чадавхыг сайжруулах</p>	<p>Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 95%-тай, үүнээс сэргээн засах, физик эмчилгээний аппаратын хангалт 85%, лабораторийн чадавх 100%-тай байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмжийн бэлэн байдлын үнэлгээг хийж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй гэрээ байгуулж эвдэрсэн тоног төхөөрөмжийг засварлах, ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах, аппарат тоног төхөөрөмж дээр ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг “Эмч” хөтөлбөрийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторийн тасаг, инженер техникийн тасагтай хамтран 11 лаборантыг хамруулж мэргэжил арга зүйгээр ханган чадавхжууллаа. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сэргээн засах, уламжлалтын 9 эмч, лабораторийн 1 эмч, 6 лаборант ажиллаж байна.</p>	100
25		<p>3.4.3 Яаралтай түргэн тусламжийн төвийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашинаар хангах.</p>	<p>Яаралтай тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд хүний нөөцийн чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төгсөлтийн дараах сургалтын сургалтад 2022-2023 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 8, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 8 суралцагчийг төгсгөж, “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 4, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 сувилагч суралцаж байна. - Хувийн хэвшлийн 7 ор бүхий клиник яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчийг ажиллуулж байна. - БОЭТ-ийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран 6 удаагийн сургалтад 45 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. - Амилуулах суурь тусламжийг сайжруулах ажил мэргэжлийн уралдааныг Монголын Яаралтай тусламжийн Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 	100

			<p>14 багийн 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, орчин үеийн технологи Kahoot, Quiz maker программыг анх удаа ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гардан болон онолын мэдлэгийг нэмэгдүүлсэн. Мөн амилуулах суурь тусламжийн сургалтад нийт 121 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, чадавхжууллаа.</p> <p>Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - БОЭТ-ийн Төрөх тасгийн хүлээн авах тасагт SAMSUNG ЭХО аппаратын датчикийг байгууллагын 45 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэж оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн. - Яаралтай түргэн тусламжийн тасаг шархны анхдагч цэгцлэлтийн багажаар хангасан. <p>БОЭТ-ийн түргэн тусламжийн тасагт туулах чадвар сайтай, бүрэн тоноглогдсон 7, хагас тоноглогдсон 4 нийт 11 машин яаралтай тусламжийн дуудлагад үйлчилж ажилласан.</p> <p>Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд орон нутгаас 285 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд нийт 14686 дуудлагад үйлчилснээс алсын дуудлага 286 буюу 1,9% байна. Нэн яаралтай тусламжийн дуудлагад 20 минутын дотор очсон хувь 100% байна. Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх, мэргэшсэн хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оноос 5 хувиар нэмэгдэж 90 хувьд хүргэсэн.</p>	
26		<p>3.4.7 Эмч нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, тэдний төлөвшил, ёс зүй, хандлагыг сайжруулах</p>	<p>Тайлант хугацаанд 2022-2023 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 191 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас төрийн сангийн санхүүжилтээр 18,3% нь суралцсан.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараах сургалтад “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 2 резидент эмч, яаралтай тусламжийн сувилахуй 7, эрчимт эмчилгээний сувилахуй 1 тус тус суралцаж, нийт төгсөлтийн дараах сургалтад 10 эмч, сувилагч суралцсан байна. Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 36,3% байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 29 эмч өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, ажил мэргэжлийн туршлага солилцох сургалтад, эрүүл мэндийн салбарын 17 сувилагчийг БНХАУ-ын Ордос, Хөх хот, БНСУ, Япон улсуудад богино хугацааны сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 72,4% ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдаж, төвийн болон орон нутагт зохион байгуулсан ажлын байран дээр дадлагажуулах 16 удаагийн сургалтад 238 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, 108 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна.</p>	90

			Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тайлант хугацаанд эмч мэргэжлээрээ бахархах, үр бүтээлтэй олон жил ажилласан эмч нарыг алдаршуулах, тэднээс суралцах зорилгоор “Эмчийн гангараа”, Ахмадаа хүндэтгэе-2023” зэрэг уулзалтыг зохион байгуулж нийт 65 эмчийг хамруулсан. Тайлант хугацаанд ёс зүйн чиглэлээр 47 удаагийн соён гэгээрүүлэх сургалтад 2257 эмч, мэргэжилтнийг хамруулсан байна. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд 2 гомдол ирснийг судлан шийдвэрлэсэн.	
27		3.4.8 Эмнэлгийн байгууллагад ажиллагчдын цалин урамшууллыг нэмэгдүүлэх, орон сууц болон бусад нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлж, хүний нөөцийн тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх, ажиллах орчин нөхцөлийг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх	Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилчдын цалин 15-18% нэмэгдсэнээр олгож байна. Засгийн газрын 2022 оны 489 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл 20%, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11/04 дүгээр тогтоолын дагуу орон нутагт ажилласны нэмэгдэл 40% нэмэгдсэнээр олгож байна. Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 03 сарын 01-ний Б/24, 2023 оны 08 сарын 21-ны Б/49 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын 5 мэргэжилтэнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг журмын дагуу нэмэгдүүлсэн. Тайлант хугацаанд Өрхийн эрүүл мэндийн төвүүд эмч, сувилагч нарын цалинг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолын дагуу нэг иргэнээр тооцсон санхүүжилтээр 1 эмч, сувилагчид 2000 иргэн ногдохоор цалинг олгож эхэлсэн нь өмнөх оны тайлант үетэй харьцуулахад үндсэн цалин 10-20%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Аймгийн Засаг даргын 2023 оны А/184 дүгээр захирамжаар эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөө, 175,0 сая төгрөгийн санхүүжилтийг батлуулан хэрэгжүүлсэн байна. Тус хөтөлбөрийн хүрээнд: - Эрүүл мэндийн салбарын 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулсан.(16.0 сая төгрөг) - Өндөр хөгжилтэй оронд суралцах болон дотоодын сургалтад хамрагдахад 71 эрүүл мэндийн ажилтанд 48.4 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон. Эрүүл мэндийн салбарын 14 ажилтан түрээсийн орон сууцаар хангагдсан бөгөөд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 1 ахмад ажилтанд аймгийн Засаг даргын тамгын газраас гэр олгосон. Тайлант хугацаанд нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 24.4%-тай байна.	100
28	Зорилт 4.2. Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай, мэргэжилтэй	4.2.1 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн “Бүсийн анагаах ухааны мэргэжил	Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв нь Монгол Улсад орон нутагт анх удаа төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн (Ерөнхий мэргэшил судлал) сургалтыг 2018 оноос эхлүүлж нийт 12 резидент эмчийн төгсгөсөн. Тайлант хугацаанд буюу 2022-2023 онд 6 резидент эмч төгсөж, 2023-2024	100

	ажилтан бэлтгэх	дээшлүүлэх төв” байгуулна.	онд буюу 6 дахь жилийн сургалтад 2 резидент эмчийг элсүүлэн сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулж байна. ЭМЯ, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс БОЭТ-ийн хүсэлт, сургалт эрхлэх чадамжийг дэмжин Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2021 оны 15-р тогтоолоор “Яаралтай тусламжийн сувилахуй”, “Эрчимт эмчилгээний сувилахуй” чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг олгосноор орон нутагт сувилахуйн төгсөлтийн дараах сургалт эрхлэх анхны эрүүл мэндийн байгууллага болсон. 2022-2023 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 8, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 8 суралцагчийг сургаж төгсгөж, “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 4, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 сувилагч элсэн суралцаж байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх 48 дахь сургалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 7 эмч эмнэлзүйн сургагч багшаар бэлтгэгдсэн.	
29	Зорилт 6.1. Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах	6.1.4 Хүн амын унд ахуйд хэрэглэж байгаа усны чанар, бохирдлын түвшин, хүн амын эрүүл мэнд, өвчлөл хоорондын хамаарлыг тогтоох тандалт судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэж, усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Орхон аймгийн Эрдэнэт ус Дулаан түгээх станц ТӨХК-ний харьяа Баян-Өндөр, Жаргалант сумын ус хангамжийн эх үүсвэрүүдийн 13 цэгийг шинжилгээнд хамруулахад химийн шинжилгээгээр стандартын шаардлага хангахгүй үзүүлэлттэй байсан тул төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгуудад шүүлтүүр тавих, угаалга халдваргүйтгэл хийж давтан шинжилгээнд хамруулах талаар улсын ахлах байцаагчийн 2 удаагийн дүгнэлт өгсөн. Эрдэнэт-Үйлдвэр ТӨҮГ-ын харьяа ус хангамжийн цэгийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн орох, гарах хэсгээс дээж авч, нян судлал, химийн бохирдлын үзүүлэлтээр шинжилгээнд хамруулахад стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан дүгнэлт гарсан. Ундны усан дахь гэдэсний савханцрын тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээж бүртгэгдээгүй. Ундны усны эрүүл ахуй мэдлэг үнэлэх судалгааг Их залуу, Эрдэнэ, Яргуйт, Дэнж багуудын төлөөлөл 200 хүнийг хамруулан хийхэд мэдлэгийн дундаж 35,8-тай үнэлэгдсэн. Тайлант хугацаанд гэдэсний халдварт өвчин 47 тохиолдол бүртгэгдэж 10,000 хүн амд 4,5 промилл байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,7 промиллоор буурсан байна.	90
30	Зорилт 12.3. Химийн бодис болон хортой хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй байдлаар устгах, тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Хүнс, хоол тэжээлийн хаягдлын дахин боловсруулалт, ашиглалтыг сайжруулах	Хүнс, хоол тэжээлийн хаягдлын дахин боловсруулалт, ашиглалтыг сайжруулах байна. Хүнсний хог хаягдлыг боловсруулж тасалгааны цэцэг, мод бутуа бордох, цаашлаад хүнсний ногоо тариалах талбайгаа бордох боломжийн талаар "Эко-34 клуб"-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд Орхон аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв сургалтын болон дотуур байрны сурагчдын хоол хүнс, ногооны хаягдлаар компост /хоол хүнсний үлдэгдлийг бордоо болгох зориулалтай машин/ ашиглан дахин	70

			боловсруулалт хийн 2022-2023 оны хичээлийн жилд 18кг эко бордоог гарган авсан.	
31		Химийн хорт хаягдал болон бусад аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах.	<p>“Ногоон ариусгал” ХХК нь 2020, 2022 онд тус тус аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг БОАЖЯ-аас авсан.</p> <p>Тус компанитай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдал хариуцсан 42 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудын дэмжлэгт хяналтыг 28 байгууллагад хийж зөвлөмж хүргүүлэн, зөвлөмжийн хэрэгжилт 85%-тай байна.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд тээвэрлэлт, устгалын үйл ажиллагааг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг “Ногоон ариусгал” ХХК-тай гэрээгээр гүйцэтгүүлж мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Ногоон ариусгал ХХК-тай 66 эрүүл мэндийн байгууллага гэрээтэй ажиллаж халдвартай хог хаягдал 119934,7кг, хурц үзүүртэй, ирмэгтэй хог хаягдал 76383,8 кг, эмгэг хог хаягдал 253,73 кг, эсийн хог хаягдал 229,2кг, химийн хог хаягдал 6,7 кг устгасан байна.</p> <p>Мөн Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2 Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 1 эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутгах автоклав төхөөрөмж хуваарилагдан ирснээр 35458 кг эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутган "Ногоон ариусгал" ХХК-д хүлээлгэн өгсөн байна.</p>	90
32		Аюултай хог хаягдал болон эмнэлгийн хог хаягдлыг байгальд хөнөөл багатай байдлаар устгах технологийг нэвтрүүлэх, шаардлагатай байгууламжийг барих	<p>Аймгийн "Хог хаягдлын менежментийг сайжруулах" хөтөлбөрийн хүрээнд “Ногоон ариусгал” ХХК-ийг дэмжин өндөр температурт хог хаягдлыг шатаах үйлдвэр байгуулах, булж устгах талбайн газрыг шинээр орон нутгаас гаргаж өгч, тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг Байгаль, орчин аялал, жуулчлалын яаманд хүргүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах, устгалын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр аймгийн хэмжээнд хог хаягдлын нэгдсэн цэгт аюултай хог хаягдал хадгалах зориулалтын байр барих ажил 75%-тай явагдаж байна.</p>	70
Хэрэгжилтийн дундаж хувь 90,6%				

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХШУДАХ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН _____ Г.ЭНХЖАРГАЛ
 ТАНИЛЦСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ _____ Д.СҮХЭЭ